



МОНГОЛ УЛСЫН
ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1998 оны 01 сарын 08-нд

Дугаар 06

Улаанбаатар хот

Гадаадад оюутан, мэргэжил
дээшлүүлэгч сургах тухай

БНСУ-ын "21 дүгээр зууны сан" байгууллагаас ирүүлсэн урилгыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гаваасамбуугийн Ундармааг цахилгаан холбооны, Сүрэнжавын Энхтуяаг электроникийн, Дэмчигдоржийн Энхбаярыг механик инженерийн мэргэжлээр Солонгос улсын Ханкукын их сургуульд, Содномцогийн Сүх-Очирыг компьютерийн мэргэжлээр, Инхагийн их сургуульд, Раднаарагчаагийн Баярыг мөн сургуулийн магистрантурт, Баянзулын Баярсайханыг АНУ-ын Колорадогийн Их сургуулийн магистрантурт 1998 оны 2 дугаар сарын 1-нээс эхлэн тус тус суралцуулсугай.

2. Г. Ундармаа, С. Энхтуяа, Д. Энхбаяр, С. Сүх-Очир, Р. Баяр нартай Монгол улсын Засгийн газрын 1997 оны 179 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу гэрээ байгуулахыг, Б. Баярсайхантай Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1997 оны 224/268 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Гадаад орны магистрантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу гэрээ байгуулж, холбогдох төлбөр хийхийг Сургалтын төрийн сангийн захирал Б.Ганбатад, энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Алтангэрэлд тус тус даалгасугай.

САЙД

Ч. ЛХАГВАЖАВ

Лууцмөр үнэн